



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

**БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН
ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/.....
Холбоо барих утасны дугаар:
Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр:
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:

Тайлбар:

1. Барилгын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3.3 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/961 дүгээр захирамж
2. Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-т заасан зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна гэж заасны дагуу холбогдох материалуудыг скайнердаж PDF өргөтгөлтэйгөөр цаасан болон цахим хэлбэрээр BAZG@uda.ub.gov.mn хаягаар ирүүлнэ үү. PDF өргөтгөлтэй файлын хэмжээ 5MB-ээс доош байна.
3. Материалын бүрдлийг PDF өргөтгөлтэй цахим хэлбэрээр ирүүлээгүй тохиолдолд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгогдохгүй болохыг анхаарна уу.

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

№	Үндэслэл, хуулийн заалт	Баримт бичгийн жагсаалт, тайлбар	Бүрдэл
1.	Барилгын тухай хууль 28.2, 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.	Захиалагчийн өргөдөл, албан бичиг. Иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар Жич: <i>Хүсэлтийг зөвхөн захиалагчаас ирүүлэх.</i>	
2.	Барилгын тухай хууль 28.2.1. Барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр.	Газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг, Хангагч байгууллагуудаас олгосон техникийн нөхцөлүүд. Жич: <i>Хугацаа хүчин төгөлдөр байх.</i>	
3.	Барилгын тухай хууль 28.2.2. Барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт.	Батлагдсан загвар зургийн дагуу боловсруулж магадлал хийгдсэн ажлын зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралтын хамт.	

4.	<p>Барилгын тухай хууль 16.2, 16.4.</p> <p>Барилга байгууламжийн тэг тэнхлэгийг зураг төсөлд тэг тэнхлэгийг зураг төсөлд заасны дагуу геодезийн тэмдэглэгээ /улаан шугам/-тэй уялдуулан тухайн барилгын ажлын талбайд барилгын геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий хуулийн этгээд тогтоож мэдээллийг нутгийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>Хот байгуулалт, хотын стандартын газрын Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн мэдээллийн санд оруулсан барилгын тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн актын хуулбар</p>	
5.	<p>Барилгын тухай хууль 28.2.3.</p> <p>Зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</p>	<p>Зураг төсөл зохиогч байгууллагын танилцуулга, Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар</p> <p><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i></p>	
6.	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль</p> <p>Барилгын тухай хууль 28.2.4.</p> <p>Байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан.</p>	<p>Дараах зориулалтын барилга байгууламжид хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> -1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц, -35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, -тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам, -орон нутгийн чанартай зам, холбоо, -шатахуун түгээх станц, -50 хүртэл болон 50-аас дээш ор хоногийн хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар -аялал, жуулчлал эрхлэх, -10000-аас дээш хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын нэгдсэн цэг. <p><i>Жич: Дээр дурдсанаас бусад зориулалтын барилга байгууламжид шаардахгүй.</i></p>	
7.	<p>Барилгын тухай хууль 8.2, 8.3, 8.4, 28.2.5.</p> <p>Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.</p>	<p>Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч нь тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулж гэрчилгээг хавсаргах.</p> <p><i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i></p>	

8.	Барилгын тухай хууль 28.3. Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана.	Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар <i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i>	
9.	Барилгын тухай хууль 28.4, 30.1 Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргана. Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.	Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх календарчилсан график төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлэх. <i>Жич: Барилгын ажлын зөвшөөрлийг календарчилсан график төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно.</i>	
10	Барилгын тухай хууль 16.3. Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.	Барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг төслийг барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр баталгаажуулж ирүүлэх.	

Жич: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/343 дугаар захирамжаар Газрын гэрээ дүгнэсэн акт, Газрын тооцоо нийлсэн актын хуулбарыг хавсаргах

Зөвлөмж:

1. Зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд нь Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ гарсны дараа Тэмдэгтийн хураамж 20.000₮-ийг Төрийн сан 100200051054 дугаар дансанд тушаана уу. *Жич: Гүйлгээний утга: Иргэн бол заавал регистрийн дугаар, цахим хаяг, аж ахуй нэгж бол байгууллагын регистрийн дугаар, цахим хаяг бичих.*
2. Барилгын тухай хуулийн 26.2-т Барилга байгууламжийн үндсэн бүтээцэд болон инженерийн шугам сүлжээний хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулсан бол зураг төслийг дахин боловсруулж, барилгын ажлын зөвшөөрөл шинээр авна гэж заасны дагуу дээрх материалыг дахин бүрдүүлж зөвшөөрлийг шинээр авна.
3. Барилгын тухай хуулийн 30.2-т Барилгын ажил энэ хуулийн 30.1-д заасан хугацаанд дуусаагүй бол захиалагч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллагад гаргаж, дуусаагүй ажлыг гүйцэтгэх бодит хугацааг тусгасан төлөвлөгөөг хавсаргана гэж заасан тул ажил дуусах хугацааг сайтар бодолцож календарчилсан графикаа батлах нь зүйтэй.
4. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн 4.8-т Барилгын тухай хуулийн 30.2-т заасан хугацаанд зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлт ирүүлээгүй бол Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгахгүй бөгөөд зөвшөөрлийн хугацаа дуусмагц гэрчилгээг хүчингүйд тооцно

Хүсэлт хүлээн авсан мэргэжилтэн /...../

/нэр/

..... оны..... сарын.....өдөр

